



ХАЛДВАРТ ӨВЧИН  
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Улирлын томуугийн эсрэг нэмэлт  
вакцинаар дархлаажуулах тухай

Монгол улсын эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улирлын томуугийн эсрэг нэмэлт вакцины хуваарийг нэгдүгээр, вакцины зааврыг хоёрдугаар, мэдээ өгөх хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эмч, эмнэлгийн ажиллагсад, эрсдэлт бүлгийн хүн амыг улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчний тандалт судалгааны алба (А.Амбасэлмаа), Дархлаажуулалтын алба (О.Дашпагма), аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга нарт үүрэг болгосугай.
3. Томуугийн эсрэг вакцины хамралтын мэдээг өдөр бүрийн 19-20 цагийн хооронд [www.flu.mn/vaccine2020](http://www.flu.mn/vaccine2020) холбоосоор мэдээг оруулна.
4. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал (Д.Наранзул)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



д. НЯМХҮҮ

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын  
 2020 оны 12 сарын 03.-ны өдрийн  
 А/64 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах  
нэмэлт улирлын томуугийн эсрэг вакцины хуваарь**

**1. Орон нутаг**

Д/д	Аймгийн ЭМГ	Вакцин (хүн тун)	Нийт вакцины тоо
1	Архангай	4,000	4,000
2	Баян-Өлгий	4,000	4,000
3	Баянхонгор	6,000	6,000
4	Булган	4,000	4,000
5	Говь-Алтай	2,500	2,500
6	Говьсүмбэр	500	500
7	Дорнговь	4,000	4,000
8	Дорнод	4,000	4,000
9	Дундговь	2,000	2,000
10	Завхан	6,000	6,000
11	Орхон	4,000	4,000
12	Өвөрхангай	5,500	5,500
13	Өмнөговь	500	500
14	Сүхбаатар	6,000	6,000
15	Сэлэнгэ	2,000	2,000
16	Увс	5,000	5,000
17	Ховд	2,000	2,000
18	Хөвсгөл	5,500	5,500
19	Хэнтий	4,000	4,000
<b>Дэд дүн</b>		<b>71,500</b>	<b>71,500</b>

**2. Нийслэл, дүүрэг**

№	Дүүрэг	Вакцин (хүн тун)	Нийт вакцины тоо
1	Налайх ЭМТ	500	500
2	Өргөө амаржих	100	100
3	Амгалан амаржих	50	50
4	Бусад эрүүл мэндийн байгууллага	290	290
	<b>Дэд дүн</b>	<b>940</b>	<b>940</b>

**3. Эрүүл мэндийн байгууллага, бусад салбарын байгууллага**

Д/д	Байгууллага	Вакцинд хамруулах зорилтотоо	Нийт вакцины тоо
1	ЭХЭМҮТ резидент эмч	300	300
2	АШУИС мэргэжил дээшлүүлэх институт	1,000	1,000
3	ЭМХТ	1,100	1,100
4	АӨСҮТ	40	40
5	УХТЭ	200	200
6	Үндэсний батлан хамгаалахын их сургууль	450	450
7	Рендэжиутай очирваань ХХК	60	60
8	ЦЕГ	3,000	3,000
9	Дотоодын цэргийн штаб	220	220
10	401 дүгээр анги	1,800	1,800
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ЕГ	610	610
12	Өөжин эмнэлэг	40	40
13	Онцгой байдлын ерөнхий газар	1,810	1,810
14	Хил хамгаалах ерөнхий газар	2,600	2,600
15	Зэвсэгт хүчин, жанжин штаб	10,690	10,690
16	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	610	610
17	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн	250	250
18	429 дүгээр анги	160	160
19	Эм Би Жи Мед	50	50
20	Угалз буянт продиз ХХК	30	30
21	Хууль сахиулах их сургууль	2,000	2,000
22	Ариутгал, халдвартгүйжүүлэлтийн нэгдсэн холбоо	200	200
23	Хүний эрхийн комисс	20	20
24	ГГСҮТ	250	250
25	Налайх ЭМТ	500	500
26	Өргөө амаржих	100	100
27	Амгалан амаржих	50	50
28	Цэргийн төв эмнэлэг	60	60
29	Хүрээ амаржих	40	40
30	Нийслэлийн ЭМБ	260	260
	Дэд дүн	28,500	28,500
	НИЙТ ДҮН	100,000	хүн тун

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын

2020 оны 12 сарын 03-ны өдрийн

5/4  
б.дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Томуугийн эсрэг 3 цэнт  
вакциныг хэрэглэх заавар



Томуугийн эсрэг 3 цэнт вакцин нь томуугийн вирусын антигенийг идэвхигүйжүүлж гарган авсан. 2020-2021 оны томуугийн улиралд ДЭМБ-ын зөвлөмж болгосон, магадлан итгэмжлэгдсэн вакцин. Вакцины найрлаганд орсон томуугийн вирусын дэд хэв шинжийн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

**Найрлага:**

Нэг хүн тун томуугийн вакцинд томуугийн вирусын гурван дэд хэвшинжийг агуулсан

А Хүрээ/ (H1N1)

А Хүрээ / H3N2

В Хүрээ/Washington

Нэмэлтээр тиомерсал, тарилгын шингэн

**Савлалт:**

Нэг хүн тун нь 0,5 мл, Флаконд 10 хүн тунгаар савлагдсан. Вакцин өнгөгүй шингэн суспенз.

**Тун ба тарих арга:**

Вакциныг булчинд тарина.

- З настай хүүхэд болон түүнээс дээш насныханд 0,5 мл-ээр нэг удаа тарина.

**Эсрэг заалт:**

- Вакцины найрлаганд орсон бодисуудад өмнө нь анафилаксийн урвал илэрч байсан
- Өндөг, тахианы гаралтай бүтээгдэхүүнүүдэд хэт мэдрэг хариу урвал өгч байсан
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт өгсөн
- Өмнө нь томуугийн вакцин хийлгэнээс хойш 6 сарын дараа Гиллен Барын хам шинж өгч байсан
- Мэдрэлийн үрэвслийн хам шинжийн үед
- Дархлал дутмагшилтэй
- Гормон эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс
- Хавдарын эмчилгээний цитостатик эм хэрэглэж буй үед
- Немомицин харшилтай

**Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:**

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих зэрэг ерөнхий, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг хэсэг газрын шинжүүд илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.
- Ховор тохиолдолд энцефаломиелит, анафилаксийн шок, харшлын урвалууд, татах, мэдрэлийн тогтолцооны ерөнхий болон хэсэг газрын үрэвсэл, амьсалахад саадтай болох хүнд урвалууд вакцин хийлгэсний дараа 2 долоо хоногийн дотор илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдэгүүд илэрвэл яаралтай эмчилгээг хийх хэрэгтэй.

#### **Анхааруулга:**

- 1) Томуугийн вакциныг бусад товлолын вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна
- 2) Тарилгын стандартыг баримтлан ажиллана
- 3) Задалсан вакциныг дараах нөхцлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
  - Вакциныг +2-+8 хэмд хадгалсан;
  - Вакцины шошго балраагүй;
  - Халдвэр хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан.
- 4) Вакцин хийлгэж байгаа хүмүүст тарьсан хэсгийг бохирдуулахгүй байлгах болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд яаралтай эмчид хандах талаар зөвлөх хэрэгтэй.

#### **Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд**

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйд вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсэний 4 дэх сараас томуугийн вакцин хийлгэж болно.

#### **Хадгалах тээвэрлэх:**

- Вакциныг +2+8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ.
- Халууны нөлөөнд орсон эсэхийг вакцин шошгоны мониторыг ашиглан хянана
- Хөлдөөж болохгүй.

**Үйлдвэрлэгч:** Бутантан институт, Бразил

ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын  
2020 оны 12 сарын 03-ны өдрийн  
164 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

### Улирлын томуугийн вакцины мэдээ авах хүснэгт

Хүснэгт 1. Эрүүл мэндийн байгууллага болон бусад байгууллагын ажиллагсдыг томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулсан мэдээ

№	Байгууллагын нэр	Хүлээн авсан нийт вакцин /хүн тун/	Тарисан вакцины /хүн тун/	Хамралтын хувь	Үүнээс		Мэргэжлээр	Насны бүлэг				ДДУХ
					Жириэмсэн	≥65		Архаг хүүн өвчтэй	Эмч	Сувилагч	Тусгай мэргэжилтэн	

Мэдээ гаргасан:

Мэдээг хянасан: